65

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 06
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.09.04 № хэг/1619

танай _____-ны №_____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХТУЯА ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолоор батлагдсан "Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам" болон Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам"-ын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Боловсролын сайдаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт 6.. хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ

9909245017960

66

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22 27, И-мэйл: letter@moe.gov.mn
Вэб сайт: moe.gov.mn

2024.09.02 № 1/739
танай 2024.08.15 -ны № ХЭГ/1488

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Хариу өгөх тухай

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Засгийн газрын 2024 оны "Журам батлах тухай" 103 дугаар тогтоолоор баталсан “Багш, багш мэргэжлийн суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”, Засгийн газрын 2024 оны "Журам батлах тухай" 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-тай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд тавьсан асуулгатай танилцлаа.

Асуулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.

П.НАРАНБАЯР

0442

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Зайсан, Их Хурлын гудамж 46,
Утас: (976-51) 26 22 27, факс: (976-51) 26 37 27,
Цахим хуудас: www.moe.gov.mn, Цахим шуудан: letter@moe.gov.mn

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын дарга

Ц.Мөнхбаатар

2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр № 0/2МЕ дугаар албан бичгээр
Монгол Улсын Их Хурлын гишүүн
Ц.Мөнхтөр нарт

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтөрийн 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 0/2МЕ дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн "Монгол Улсын Их Хурлын тухай" Монгол Улсын хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд хүсэлт гаргах тухай" асуудлыг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэхээр Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 08 дугаар захирамжаар тогтоосныг мэдэгдэж байна.

Монгол Улсын Их Хурлын дарга Г.ЗАНДАНШАТАР

68

Хавсралт.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас
Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд тавьсан асуулгын хариу

Нэг. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 103 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Багш, багш мэргэжлийн суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд:

1.1. 2023-2024 оны хичээлийн жилд хичээллэсэн Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заасан багш мэргэжлийн сонгон бүлгийн болон түүнд суралцагсдын тоо, энэхүү журмаар дэмжлэг авч суралцсан суралцагчдын тоо, түүнээс хэд нь хэчнээн төгрөгийн дэмжлэг хүртсэн тухай мэдээ

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан багш мэргэжлийн сонгон бүлгийн төгсөгч байхгүй бөгөөд холбогдох санхүүжилтийн тооцоо 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн хийнэ.

1.2. 2023-2024 оны хичээлийн жилд бакалаврын сургалтын хөтөлбөрөөр хэдэн суралцагч дэмжлэгт хамрагдсан, түүнд зарцуулсан мөнгөн дэмжлэгийн дүн

2023-2024 оны хичээлийн жилд "Багш, багш мэргэжлийн суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу:

- 2.1.2-т заасан "багш бэлтгэх бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрөөр 657 суралцагч"-ийн 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилт;
- 2.1.5-т заасан Боловсролын ерөнхий хуулийн 12.10-д заасан орон нутагт мэргэжлээрээ ажиллах багш /хөрвөх/ 88 суралцагчийн 155.4 сая төгрөгийн санхүүжилт;
- Багш бэлтгэх бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцагч /өндөр оноо/ 680 суралцагчийн 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

Бакалаврын сургалтын багш мэргэжлийн үндсэн хөтөлбөрөөр суралцаж байгаа нийт 1425 суралцагчид Боловсролын зээлийн сангаас 2.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

1.3. 2023-2024 оны хичээлийн жилд боловсролын чиглэлээр магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр хэдэн суралцагч нийт хэчнээн төгрөгийн дэмжлэг авсан тухай дүн:

Журмын 2.1.3-т заасан боловсролын чиглэлээр магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр багш бэлтгэдэг их сургуулиудад суралцаж байгаа 19 суралцагчид 22.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

1.4. 2023-2024 оны хичээлийн жилд Багшийн хөгжлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасан хэдэн суралцагч, нийт хэчнээн төгрөгийн дэмжлэг авсан тухай дүн

Журмын 2.1.4-д заасан Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.3-т заасны дагуу хөдөө орон нутагт багш мэргэжлээр дадлагажигч 452 суралцагчид 364.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

1.5. Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батлах" гэж заасан байдаг. 2023-2024 оны хичээлийн жилд энэ дэмжлэгийг хэчнээн багш, ажилтны хэдэн хүүхэд авч, нийтдээ хэдэн төгрөгийн дэмжлэгийг олгосон тухай дэлгэрэнгүй тайлан

Журмын 2.1.6-д заасан "Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6 дахь зүйлийн дагуу багш, ажилтны нэг хүүхэд" гэсэн заалтаар багш, ажилтны 233 суралцагчид 552.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

1.6. Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.6-г хэрэгжүүлэхэд "15 -аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх", "тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр" гэсэн шалгуурын дагуу хэчнээн багш, ажилтны хүүхэд хасагдсан тухай мэдээ

Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.6 дах заалтыг хэрэгжүүлэхэд "15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх", "тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр" гэсэн шалгуурын дагуу судалгаагаар багш, ажилтны нийт 264 суралцагч хасагдсан.

1.7. Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журмын 2 дугаар дугаар зүйлийн "2.2.3.Боловсролын ерөнхий хуулийн 12.5, Дээд боловсролын тухай хуулийн 12.12-т заасны дагуу магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийг сонгосон байх" шаардлагын дагуу хэдэн, багш, ажилтны хүүхэд дэмжлэг авч чадаагүй, хохирсон талаарх мэдээ

Журмын 2.2.3-т заасан "Боловсролын ерөнхий хуулийн 12.5, Дээд боловсролын тухай хуулийн 12.12-т заасны дагуу магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийг сонгосон байх" шаардлагын дагуу судалгаагаар 176 суралцагч хасагдсан.

1.8. Цаашид Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6-д заасан "15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх", "тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцах", журмын 2.2.3-т заасан "магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийг сонгосон байх" гэсэн хэт явцуу, багш, ажилтнуудад дэмжлэг биш ялгаварлал

үүсгэсэн энэхүү хатуу заалтуудыг хэрхэн уян хатан, хүртээмжтэй болгохоор ажиллаж байгаа тухай мэдээлэл

Хуульд заасан боловсролын сургалтын байгууллагад 15-аас доошгүй жил тасралтгүй буюу тогтвор суурьшилтай ажилласан багш, ажилтны нэг хүүхэд Засгийн газрын 2023 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг хөгжүүлэхэд шаардлагатай дээд боловсролын магадлан итгэмжлэгдсэн буюу чанартай 83 тэргүүлэх, 38 эрэлттэй мэргэжлийн хөтөлбөрөөр суралцах боломжтой. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 146 дугаар тушаалын дагуу нийт 416 хөтөлбөрийн индекс батлагдсан. Боловсролын ерөнхий хуулийн 11.5-д заасны дагуу тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцагч сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдэлж, тэтгэлэг, зээл авах боломжтой. Мөн хуулиар тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийг тодорхойлох аргачлал, жагсаалт таван жил тутам шинэчлэгдсэнээр багш, ажилтны нэг хүүхэд хамрагдана.

Цаашид өмнөх жилд багш, ажилтны хүүхдүүд элссэн эсвэл суралцаж буй “магадлан итгэмжлэгдээгүй” хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллана.

1.9. Цаашид энэхүү журмыг “Багш, багш мэргэжлийн суралцагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг”, “Багш, ажилтны хүүхдийг төрийн өмчийн их, дээд сургуульд суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам” болгон салгаж болох эсэх

Дэмжлэгийг санхүүжилтийн нэг эх үүсвэрээс буюу Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3-т заасны дагуу Боловсролын зээлийн сангаас санхүүжүүлж байгаа, дэмжлэгийг авч байгаа иргэд нь Боловсролын ерөнхий хуулийн 3.1.11-т заасан “суралцагч” тул нэг журмаар зохицуулсан болно.

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 104 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ын хүрээнд

2.1. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд 2024 оны улсын төсөвт хэчнээн төгрөг суулган олгож байгаа тухай мэдээлэл

2024 онд төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд олгох мөнгөн тэтгэмжид 105.3 тэрбум төгрөг зарцуулна.

2.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дүгээр зүйл 139.1-т “Гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна” гэж заасан байдаг ч энэхүү журмын 2 дугаар зүйлийн 2.3.7-д “жирэмсний болон амаржсаны

амралттай, хүүхдээ асрах чөлөөтэй байсан эхний нэг жил (12 сар) хүртэлх хугацаа"-г тасралтгүй ажилласан жилд хамааруулан тооцохоор зохицуулжээ. Нэгэнт хууль зөрчөөгүй, харин ч хуулиар нээлттэй учраас жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхдээ асрах чөлөө авсан гурван жил (36 сар) хүртэлх хугацааг тасралтгүй ажилласан жилд хамааруулан тооцох боломжтой гэж үзэж байна. Энэ талаар Засгийн газар ямар байр суурьтай байгаа вэ?

Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 139.1-д "...тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж..."-оор гэж заасны дагуу энэхүү журамдаа "эхний нэг жил буюу 12 сар" байхаар тусгасан. Журамд "жирэмсэн болон амаржсаны хугацаа"-г мөн тасралтгүй ажилласан жилд тооцож байгаа тул нийтдээ 16 сарыг тасралтгүй ажилласан жилд тооцохоор зохицуулсан ба энэ хугацааг бусад салбарын мөнгөн тэтгэмжийн журамтай харьцуулж судалсан. Тухайлбал Засгийн газрын 2023 оны 185 дугаар тогтоолоор батлсан "Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох" журамд 12 сар хүртэлх чөлөөтэй хугацааг тасралтгүй ажилласан жилээр тооцсон байдаг.

2.3. Боловсролын ерөнхий хууль батлагдах (2023 оны 07 дугаар сарын 07)-аас өмнө энэхүү асуулгын 2.2-т дурдагдсан харилцааг хэрхэн зохицуулж байсан.

Боловсролын ерөнхий хууль батлагдахаас өмнө Боловсролын тухай хуулийн 43.1.7-д заасны дагуу томилогдсон өдрөөс хойш тасралтгүй таван жил (60 сар) ажилласан багш, ажилтанд 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгож ирсэн.